

# Монголын Материал Судлал Гагнуурын Нийгэмлэгийн 2021 оны үйл ажиллагааны тайлан

ММСГНийгэмлэгээс тайлангийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

## А. Зохион байгуулалт сурталчилгааны чиглэлээр

1.Нийгэмлэгийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл дээр УЗ-ийн гишүүдийн саналыг авч тусган боловсруулж УЗ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажилаллаа. Нийт 23 заалт бүхий төлөвлөгөөний гүйцэтгэл 70 биелжээ. Биелэгдээгүй ажлууд нь COV-19 цар тахлын хорио цээрээс шалтгаалсан байна.

2.Нийгэмлэгийн үйл ажиллагааны тайланг „Төрийн бүс байгууллагын тухай” хуулийн дагуу Улсын Бүртгэлийн Газарт дараа оны 1-р сарын 15-ны дотор албан ёсоор гарган өгч ажилласан ба татвар нийгмийн даатгалын төлбөр, тооцоо, тайланг хуулийн хугацаанд хийж, хэрэгжүүлж ирсэн.

3.Нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар гишүүн байгууллагууд, ААН, хувь хүмүүст танилцуулах, сурталчлах, гагнуурын мэргэжлийг олон нийтэд түгээх зэрэг ажлууд байнга хийж ирсэн. Нийгэмлэгийн [www.mmsws.mn](http://www.mmsws.mn) веб сайтад мэдээллээ тогтмол байршуулж ажиллав.

4.Нийгэмлэг рүү ажил төрлийн холбоо тогтоох, хамтран ажиллах, сургалтанд хамрагдах, зөвөлгөө авахаар хандсан ААН, хувь хүмүүст туслалцаа үзүүлж ажилаллаа.

5.Монголын анхны гагнуурын мэргэжлийн „Гагнуур” сэтгүүлийн 2 дахь дугаарыг ГОУХАН/GIZ/- тэй хамтран гаргаж гишүүн байгууллагууд, ААН, хувь хүмүүст 500 ш тараав.

Сэтгүүлийн дугаарт нийгэмлэгийн зүгээс зохион байгуулж шинээр батлуулсан гагнуурын чиглэлийн 6 стандартын талаар болон ТТПКоллежийн гагнуурын багш Баяраагийн сурвалжлага нийтлэл, Казанийн дэлхийн үр чадварын гагнуурын мэргэжлийн оролцогч Оюун-Эрдэнийн ярилцлага, гагнуурын мэргэжлийн хичээл, гагнуурын төслийн хэрэгжилт, мэргэжлийн гагнуурчдын улсын аваргын тэмцээний талаар зэрэг материалууд гаргалаа.

6.ММСГН-ийн өөрийн бие даасан, гагнуурын атестатчлал шалгалт авах 3 кабин бүхий цэг бий болгон тохижуулах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд гагнуурын 3 ш шинэ аппарат хэрэгсэл бусад төхөөрөмжийн хамт худалдан авч тусгаарлах хана барих, 40 тн контейнерт сэлбэг хэрэгсэл, материалаа байрлуулах зэрэг ажлуудыг хийлээ.

7.ХБНГУ ын ОУХАгентлаг GIZ-ийн Гагнуурын салбар дахь төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн нэгжтэй хамтран ажиллаж гагнуурын мэргэжлийг сурталчлах ажлыг хийлээ.

8.ММСГН-ээс зохион байгуулж гагнуурын чиглэлийн олон улсын 6 стандартыг үндэсний стандартаар батлуулсан талаар болон цаашид эдгээр стандартыг мөрдөхийг зөвлөсөн албан тоотыг ХНХЯам, ЭХЯам, МБСУМАЗТөв, ЭХХТөв, ДЦСтанцууд, УБТЗ, МИАТ зэрэг газрууд болон гишүүн байгууллагууд рүү илгээсэн.

## Б. Атестатчлал, сургалт, стандартын чиглэлээр

1.Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2010 оны 01 сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан „Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж зэрэг олгох дүрэм”-ийн

дагуу Оюутолгой ХХК, Эм Пи Ай, Хасу Мегаватт ХХК, MCS property LLC, MURRAY MINING SERVICES, Хан Оч Марал зэрэг 13 компани, ААН болон хувь 5 хүн зэрэг нийт 212 мэргэжлийн гагнуурчдаас гагнуурын атестатчлалын шалгалт авчээ.

Мөн үүнээс гадна ГММСҮТөвийн 158 гагнуурчдаас мэргэжлийн шалгалт авсан байна.

2.Инженер техникийн ажилтнуудын сургалтаар MCS LLC 7 ажилтанд „Гагнуурын оёдлын гадна дотоод гэмтэл согогийг судлах” сургалт, ДСМ ХХК-ийн 6 ажилтанд „Өндөр хэмээр зүсэх” сургалт зохион байгуулав.

3.МБСҮМАЗТөвтэй хамтран үнэлгээ баталгаажуулалтын чиглэлээр 3 хүнийг сургалтанд хамрууллаа.

4.ХБНГУ-ын оролцоотойгоор хийгдэж буй,, Гагнуурын салбар дахь стратегийн түншлэл” төслийн хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гагнуурын 6 стандартыг Стандарт Хэмжил Зүйн Газраар үндэсний стандартаар батлуулах ажлыг эцэслэн дуусгав.

Үүнд: 1. Гагнуурчны мэргэжлийн шалгалт. Хайлуулж гагнах. 1-р хэсэг. Ган,

MNS ISO 9606-1:2021

2. Гагнуурчны мэргэжлийн шалгалт. Хайлуулж гагнах. 2-р хэсэг. Хөнгөн цагаан, түүний хайлш,

MNS ISO 9606-2:2021

3. Гагнуурын холболтын үл эвдэх сорил. Хайлуулж гагнасан холболтын гадна үзлэгийн сорил

MNS ISO 17637:2021

4. Металлын гагнуурын холболтын эвдэх сорил. Хугалах сорил

MNS ISO 9017:2021

5. Гагнуур. Хөнгөн цагаан, түүний хайлшийн нуман гагнуурын холболт. Согогийн чанарын түвшин

MNS ISO 10042:2021

6. Гагнуур. Ган, диц, жуугаан ба тэдгээрийн хайлшийг хайлуулж гагнасан холболт. (цацрагийн гагнуур хамаарахгүй) Согогийн чанарын түвшин

MNS ISO 5817:2021

5. Нийгэмлэгийн УЗ-ийн гишүүн С.Батсайхан Эрчим хүчний салбарт хэрэглэгдэх ОХУ-ын СТО 70238424.27.100.005-2008 стандартыг орчуулах,хянах ажлыг зохион байгуулж ЭХЭЗХүрээлэн, ЭХЯамны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг хийлээ.

6.МБСҮМАЗТөвийн зохион байгуулсан 2 хоногийн сургалтанд УЗ-ийн 1 гишүүн оролцож Нийгэмлэгийн дэргэдэх Гагнуурын мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн.

В. Мэргэжлийн уралдаан тэмцээний чиглэлээр

1. Нийгэмлэгийн зүгээс ХНХЯам, МБСУМАЗТөвтэй хамтран мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд гагнуурын мэргэжлээр суралцагсдын дунд „Монгол үр чадвар-2021” эхний шатны тэмцээнийг 2021 оны 10-р сарын 21-нд зохион байгуулж Улаанбаатар, Дархан хот, Өмнөговь, Төв аймгуудын 10 сургуулиас шалгарсан 12 шилдгүүд оролцлоо.

Оролцогчид дэлхийн үр чадварын тэмцээний 1-р модуль буюу цахилгаан гар нуман гагнуур, хагас автомат, аргон гагнуураар 10,12 мм хавтан, 60\*4 мм-ийн ган хоолой зэрэг бэлдцүүдийг гагнаж өрсөлдсөн.

Нийгэмлэгийн үнэлгээчдийн хөндлөнгийн дүгнэлтээр авбал зохих 25.8 онооноос М.Энх-Амгалан /Скиллтек МСУТ/ 7.2 оноогоор 1-р байр,

Д.Амаржаргал /ГММСУТ/ 4.7 оноогоор 2-р байр, Э.Мандах /ТТПКоллеж/ 3.3 оноогоор 3-р байр эзэлсэн.

2. ХНХЯамны захиалгаар „Монгол үр чадвар-2021” тэмцээний 2-р шатны шалгаруулалтыг тус нийгэмлэгээс 2021 оны 12-р сарын 13-16 хооронд 4 өдөр ГММСУТөв дээр зохион байгуулав.

Тэмцээнд эхний шатнаас шалгарсан 3 оролцогч Дэлхийн үр чадварын тэмцээний иж бүрэн 4 модулийг гагнуурын 4 төрлөөр гагнаж өрсөлдөв. Гагнасан модулиуд нь 114\*85 мм ган хоолой, 10.0, 12.5, 16.0 мм-ийн ган хавтан, даралтат сав, хөнгөн цагаан болон зэвэрдэггүй ган хийц зэргээс бүрдсэн. Үнэлгээг гадна үзлэг, эвдэх болон үл эвдэх сорил /радиограф/, усан шахалтын аргуудаар хийсэн. Эцсийн дүнгээр авбал зохих 100 онооноос Д.Амаржаргал /ГММСУТ/ 39.7 оноо, М.Энх-Амгалан /Скиллтех/ 36.3 оноо, Э.Мандах /ТТПК/ 10.8 оноо авлаа.

Уг тэмцээнд түрүүлсэн Д.Амаржаргалд ХНХамгааллын сайд А.Ариунзаяа 2022 онд Шанхайд болох Дэлхийн үр чадварын тэмцээн/WORLD SKILLS COMPETITION/-д Монгол улсаа төлөөлж оролцох батламж гардуулав.

Нийгэмлэгийн зүгээс дээрх тэмцээнүүдийн удирдамж, техникийн даалгавар, зураг боловсруулах, тэмцээний үнэлгээчдийг албан газруудтай нь тохиролцож томилох, тэмцээнийг зохион байгуулах, үнэлгээ хийх, модуль бэлдцүүдийг бэлтгэх, техникийн зөвөлгөөн хийх, ХНХЯ-ы ажлын хэсгийн хурлуудад оролцох зэрэг ажлуудыг хийлээ.

Тайлан бичсэн:

Н.Мягмарсүрэн / ММСГН-ийн гүйцэтгэх захирал/

2022.02.09

Улаанбаатар

